




Empowered lives.
Resilient nations.

ДАЯН ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ САНГИЙН
ЖИЖИГ ТӨСЛИЙН ХӨТӨЛБӨР
ТӨСЛИЙН ФОТО ТАЙЛАН

Төслийн дугаар:	MON/SGP/OP6/Y3/CORE/LD/2017/13
Төслийн нэр:	Кинва будаа тариалж, хөрсний доройтол, эвдрэлийг бууруулж, ургацын хэмжээг нэмэх
Төсөл хэрэгжүүлэгч:	Монголын Кинва Тариалагчдын Холбоо ТББ
Төсөл хэрэгжсэн хугацаа:	2017.04.19 - 2018.12.01
Хэрэгжсэн газар нутаг:	Төв аймаг, Мөнгөнморьт сум Дундговь аймаг, Гурвансайхан сум Дорнод аймаг, Баяндун сум Сэлэнгэ аймаг, Баянгол сум Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум Сүхбаатар аймаг, Онгон, Дарьганга сум Улаанбаатар хот
Гол хийгдсэн ажлууд:	Кинва будааны туршин тариалалтыг газар нутаг, хөрс, цаг уурын ялгаатай шинж чанар бүхий газруудад явуулж, кинва будааны ургалт, байгаль орчинд нөлөөлөх байдлыг судалсан.


2018 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД



ТАРИАЛАЛТ

ҮРИЙН БУДАА ХУДАЛДАН АВАЛТ:

Нидерланд улсын Датч Кинва Групп Компаниас нийт 200 килограмм Жесси, Риобамба нэртэй, сапонин агуулдаггүй үрийн будаа худалдан авсан.



ХӨРС БОЛОВСРУУЛАЛТ, ТАРИАЛАЛТЫН ЯВЦ

1. Төв аймгийн Мөнгөнморьт сум, Балдан гуайнх

Балдандорж гуай өөрийн хашаанд ногоо тарьж байсан (8 м*15 м) талбайгаа бууцаар бордож, урьдчилан сайтар усалж бэлдсэн хөрсөн дээр будаагаа тарьсан. Бороогүй өдрүүдэд хөрсөө чийглэн байнга услах, зэрлэгийг нь зулгаах зэргээр талбайгаа сайтар тордсон. 5 сарын 19-нд тарьсан өдрөөс хойш 119 хоногт будааны болц гүйцсэн. Жесси, Зено сортын үрээр тарьсан будааны ургамлууд хоорондоо булцуу, ишний өнгөөрөө ялгарч байсан.







2. ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ТОСОНГИЙН ТАЛБАЙ

Урд жил нь төмс, ногоо тарьж байсан талбай байсан ба үрээ суулгахдаа чийгтэй хөрсөн дээр суулгаснаас хойш будааны ургалтын ялцад нэмэлт услалт, хөрсний бордоо хэрэглээгүй, байгалиар нь ургуулсан. 8 сарын дунд үед талбайн нэг хэсгийн зэрлэгийг зулгааж цэвэрлэсэн. Будааны болц 5 сарын 23-нд тарьсан өдрөөс хойш 125 хоногт гүйцсэн. Сапонингүй сортын будаа учраас болц гүйцэх үед шувуу маш их цугларан будааныхаа нилээд хэсгийг алдчихсан ч гэсэн чамлалтгүй ургац авсан.



3. ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМ, ПҮРЭВЖАВ ГУАЙН ТАЛБАЙ

Хаврын салхи, түйрэнгээс сэргийлж хашаатай газар сонгон, Пүрэвжав гуайн хашаанд тарьсан. Хуурай, халуун бүс нутаг учраас тариалалтын эхний 1 сарын туршид тогтмол усалж байсан. Жесси, Зено гэдэг хоёр өөр сортын үрийг 5 сарын 29-нд суулган, будааны болц 108 хоногт гүйцсэн.





4. ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМ – ИРГЭН БАТААГИЙНХ

Малын бууцтай хашаагаа томсгон татаж, хөрсөө хагалж, хог ургамлыг нь цэвэрлэн, 5 сарын 25-нд үрээ гараар болон төмөр багаж ашиглан суулгасан. Эхний 1 сарын хугацаанд усалснаас хойш нэмэлт усалгаа хийгээгүй. Усалгаатай талбай гэж үзвэл бусад газруудтай харьцуулахад арай давжаа, салаа мөчир багатай, будааны булцуу маш жижигхэн ургасан. Будааны болц 113 хоногт гүйцсэн.



5. ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМ - Иргэн Түвшингийн талбай

Түвшин-гийн гадаах малын хашааг томсгон хашаа татаж 30м * 25 м (750 м2) талбайд тариалалтыг 5 сарын 30-нд хийсэн. Усалгааг эхний нэг сард хөрсөө хуурайших бүрт хийж байсан. Будааны булцуу, иш, салаа мөчир сайтай, талбай нь хог ургамал, зэрлэг багатай байлаа. Будаа болц 115 хоногт гүйцсэн, гэвч шувуунд ургацаа бүгдийг нь алдах дөхсөн.



6. ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМ - Иргэн Н. Төгсөөгийн талбай

2017 онд энэ хашаандаа анх кинва будааг бага хэмжээгээр тарьж үзсэн туршлагатай байсан. Энэ оны тариалалтаа 6 сарын 08-нд эхэлсэн ба үр суулгахдаа усалснаас хойш нэмэлт усалгаа, бордоо хийлгүйгээр байгалиар нь ургуулсан. талбайдаа усалгаа огт хийгээгүй, зэрлэгээ 8 сард зулгааж цэвэрлэсэн. Талбайн хэмжээнд жигд, булцуу сайтай ургаж, будааны болц 120 хоногт гүйцсэн.



7. СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМ (БАРУУНХАРАА)

Нийт 11 га талбайг хагалж үрээ 6 сарын 2-ноос 7-ны өдрүүдэд үрлэгч машинаар суулгасан. 6 сарын ихэнх өдрүүд, 7 сарын эхэн хүртэл хур бороогүй, хуурай, халуун өдрүүд үргэлжлэн, будааны соёололтод муугаар нөлөөлсөн. Талбайд нэмэлт усалгаа, бордоо ашиглаагүй, талбайн 60%-ийг гялгар уут дэвсэж тарьсан. Хөрсний боловсруулалт дутуугаас, мөн үрээ хэт гүнд суулгасан зэрэг нь будааны ургалтад муугаар нөлөөлсөн.





8. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМ (ЧОЙР ХОТ)

Шивээ овоогийн нүүрсний уурхайн хаялга усыг түшиглэн, орон нутгийн иргэдийн төмс, ногоо тарьдаг талбайд будаагаа тарьсан. Үрээ зориулалтын үрлэгч машинаар 6 сарын 5-нд суулгасан ба хөрсний боловсруулалт, үрийн гүн суултаас шалтгаалан ургац буурсан.



9. СУХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМ, ИРГЭН Д. ЭРДЭНЭТУЛГЫН ТАЛБАЙ

Хашаандаа янз бүрийн эмийн ургамал, хүнсний ногоо тарьдаг Н. Эрдэнэтулга будааны тариалалтыг машид сонирхон 5 сарын 19-нд эхэлсэн. Будааг ургуулах арга, технологийн дагуу, талбайдаа арчилгаа тордолгоо сайтайгаар ургуулсан нь будааны ургалтын хурд, өнгө зүснээсээ харагдаж байсан. Будааны болц 114 хоногт гүйцсэн.



10. СУХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМ, ИРГЭН ЭНХБААТАРЫН ТАЛБАЙ

Хөрс нь элсэрхэг, жижиг үйрсэн элсэн чулуулагтай, цаг агаар хуурай, халуун газар байв. 6 сарын 10-нд үрээ суулгасан. Будааны болц 110 хоногт хангалттай сайн гүйцээд хурааж амжаагүй байтал гайхалтай уран тоншоотой сумын бүх шувууны хоол болсон.



11. УЛААНБААТАР ХОТ АМГАЛАН, ИРГЭН Н. ТӨГӨЛДӨРИЙН ХАШААНД

Амгалангийн өртөөний ойр амьдардаг Н. Төгөлдөр өөрийн хашаандаа 16 ширхэг автомашины хаягдал дугуйг ашиглан будаагаа 5-р сарын 18-ны өдөр тарьсан. Хөрс нь чулуу ихтэй, шаварлаг, нягт, хатуу чанартай байсан ч будаа сайхан ургасан. Будааны иш, булцуу сайтай, жигд өндөр ургасан.





12. УЛААНБААТАР ХОТ, ШАДИВЛАН ЗУСЛАНД, ИРГЭН Ж. БААТАРСҮРЭНГИЙН ХАШААНД

5 сарын 13-нд суулгасан, нэмэлт усалгаа, бордоо хийгээгүй. Тарьсны дараа бороо хур муутай, хөрсний чийг дутмагаас шалтгаалан 1 сар болж байж соёолж гарсан. 9 сарын 20-нд орсон цас, шуурганы үеэр иш, мөчир нь хугарч унаагүй, булцуу нь хөлдөөгүй хэвээр байсан. Будааны болц 140 орчим хоног болж байж гүйцсэн.





13. УЛААНБААТАР ХОТ, 3-Р ХОРООЛЛЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ХАШААНД





14. УЛААНБААТАР ХОТ, САНЗАЙ ЗУСЛАНД



УРГАЦ ХУРААЛТ





ТАНИУЛАЛТ

ТАНИЛЦУУЛГА, СУРГАЛТУУД

Төв аймгийн Мөнгөнморьт суманд 2018 оны 5-р сарын 2-ны өдөр хийсэн сургалт, танилцуулга.




Дундговь аймгийн Гурвансайхан сумын төлөөлөгчдөд 5-р сарын 11-ний өдөр танилцуулга, сургалтыг хийсэн.



Дорнод аймгийн Баяндун сумын иргэдэд 2018 оны 09-р сарын 27-нд сургалт, танилцуулга зохион байгуулав.





ТАРИАЛАЛТЫН ГАРЫН АВЛАГА НОМ

Тариалалтыг эхлэхийн өмнө 5-р сард “Кинва будааны танилцуулга, тариалах Агромөрдөмж”-ийг боловсруулан, төслийн тариаланчдад болон сургалтанд оролцогсдод тарааж өгсөн.

БАРИМТАТ КИНО

2018 оны 4 сараас 12 сарыг хүртэл хийгдсэн бүх ажлын зураг, бичлэгүүдээ нэгтгэн баримтат кино эвлүүлэг болгон бэлтгэлээ. Энэ эвлүүлгээ телевизүүд, мэдээний веб хуудсуудад өгч олон нийтэд мэдээлэл цацахаар бэлдэж байна.

ҮР ДҮНГИЙН УУЛЗАЛТ

Төслийн хэрэгжүүлэгч бүх аймгийн төлөөллийг оролцуулсан үр дүнгийн уулзалтыг 2018 оны 11 сарын 30-ны өдөр зохион байгуулав.



ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ҮР ДҮН

- Зургаан аймаг, нэг хотын нийт 14 газарт, нутгийн 60 гаруй иргэдийг оролцуулсан кинва будааны туршин тариалалтыг хийлээ. Нийт 23 га газрыг хамарсан талбайд үрээ суулган, Сэлэнгийн Баянгол, Дорнодын Баяндун, Төв аймгийн Мөнгөнморьтод хашаа хороог шинээр барьж, заримыг засаж янзлав.
- Кинва будааны Жесси, Риобамба (сапонингүй), Зено (сапонинтой) үрийн сортыг туршин, Монгол улсын элсэрхэг, цөлжсөн, хур бороо багатай бүс нутаг, атаршсан газарт тариалахаас гадна, төмс ногоо, үр тариа тарьж байсан талбайд сэлгэн тариалалтад зохимжийг тодорхойлохоор тарьсан туршилтууд амжилттай боллоо.
- Хөрсний шинжилгээний үр дүнгээс харахад кинва будаа ургуулсан талбай нь хөрсний pH-ийн үзүүлэлтээр сөрөг нөлөөнд ороогүй, харин эсрэгээр эерэг байдал буюу хэвийн болж хувирах нөлөө гарсан. Хөрсний давсны хэмжээ үл мэдэг буурах хандлагатай болсныг дүн харуулав. Кинва будаа нь ургамлын иш, навч, будааны масс ихтэй ургадаг таримал бөгөөд эдгээр нь дан хөрсний үржил шимийг ашиглах байдлаар бус харин фотосинтезийн урвал, био нийлэгжлээр үүсгэж ургадаг юм байна гэсэн нэг дүгнэлтэнд хүргэж байна. Кинва будаа ургахдаа хөрсний механик бүтцийг муудуулах сөрөг нөлөө огт үзүүлээгүй. Ихэнх цэгийн талбайн хөрсний бүтэц сайн тал руу болж хувирсан байна. Тухайлбал элсэнцэр хөрс хөнгөн шавранцар болж, сул элсэнцэр хөрс элсэнцэр болж өөрчлөгдсөн нь үүнийг батална. Иймээс кинва будааны талбай нь салхины элэгдэл, эвдрэлд орох эрсдэл багатай байна гэсэн урьдчилсан дүгнэлт гарсан.
- Хөрсний доройтолд орсон, ургамал ургахаа больсон газрууд болон уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газруудын нөхөн сэргээлтэд ашиглаж болохоор Монголд ургасан будааны үрийн нөөцийг гаргаж авлаа.
- Малын тэжээлд кинва будааны сүрлийг ашиглах судалгааны талаар Нидерланд улсын Датч Кинва Групп ба Финланд улсын Хелсинкийн Хөдөө аж ахуйн их сургуулийн судлаач, эрдэмтэн Милтон Унтиверос (Milton Untiveros)-той холбоотой ажиллан холбогдох материалыг судалж, орчуулж гаргалаа. Энэ жилийн тариалалтаас гарсан сүрлийг малын тэжээлд ашиглан үр дүнг бодит байдалд судлах, нотлох боломжтой боллоо.
- Дундговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Дорнод, Төв аймгуудад хийсэн сургалт, танилцуулгын явцад нутгийн иргэд энэ будааны ашиг шим, тариалалтын талаар, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд ач тустай талаар анхан шатны мэдлэгийг авлаа.